

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-16
<hr/>	
1.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	6-7
2.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	7-14
3.“Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүнээс 2024.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	14-16

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Ө.Шижир, Б.Батбаатар, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Одбаяр.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу нарын 19 гишүүнээс 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Засгийн газраас 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, мөн яамны Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Д.Мөнхбат, Далай ашиглалт, усан замын хэлтсийн дарга Д.Жавхлан, Хуулийн хэлтсийн дарга С.Мядагмаа, мөн хэлтсийн ахлах шинжээч Б.Цэнд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Зулпхар, С.Бямбацогт нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүнээс 2024.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн гарчгийн “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” гэснийг “Засгийн газарт чиглэл өгөх тухай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн тэмдэглэх хэсгийн “БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, бүрэн эрхт элчин сайд, ХХ зууны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн 1 дүгээр заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, хөдөлмөрийн баатар, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэх өдрийн товыг тогтоож, ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

2/Жамсрангийн Самбуугийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, төрийн албыг төлөвшүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;

3/ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 3.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн 1 дүгээр заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, хөдөлмөрийн баатар, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэх өдрийн товыг тогтоож, ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

2/Жамсрангийн Самбуугийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, төрийн албыг төлөвшүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;

3/ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн 2 дугаар заалтын “үүрэг болгосугай” гэснийг “даалгасугай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 40 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 24 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2025 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоомжийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал. 2.Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 3.“Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024 оны 12 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэх эсэх, хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцье. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан ТББХ хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэсэн ийм заалт байгаа. Тэгээд энэ заалтын дагуу энэ хэлэлцүүлэг явуулна.

Улсын Их Хурлын, энэ чинь юу байна шүү дээ энэ 1 дүгээр асуудал. Он, сарыг нь танилцуулна. Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу нарын 19 гишүүнээс 2024 оны 12 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хуралдаанд 14 гишүүн оролцсоноос 7 гишүүн дэмжиж, 50 хувиар санал дэмжигдсэнгүй. Баярбаатар гишүүн горимын санал гаргаж байна.

Б.Баярбаатар: Сая санал хураалтын томъёоллыг ойлгоогүй санал хураалтаас хоцорчихлоо. Тэгэхээр хүчингүй болгож өгөх горимын санал гаргаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Саяын явуулсан саналыг хүчингүй болгоё гэснээр санал хураалт явуулъя. Санал хураалт. Засгийн газар 2024 оны 12 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тухай, дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 10 гишүүн оролцож 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Засгийн газар 2024 оны 12 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Батлан хамгаалах техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн дэмжиж, 86,7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

14.29 цаг

Хоёр. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

2 дугаар асуудалдаа орёе. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлгийг явуулна. Ажлын хэсэг байгаа билүү? Ажлын хэсгийг оруулъя. Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан танилцуулна. Дэлгэрсайхан гишүүний микрофоныг.

Ажлын хэсгийг танилцуулаадахъя. Х.Итгэл Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын зохицуулалтын газрын дарга, Д.Мөнхбат Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга, С.Мядагмаа Зам, тээврийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Б.Цэнд Зам, тээврийн яамны Хуулийн хэлтсийн ахлах шинжээч, Т.Жавхлан Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга. Дэлгэрсайхан сайд. Дэлгэрсайхан сайдын микрофоныг нээе.

Б.Дэлгэрсайхан: Уучлаарай. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд тус хуулийн 10 дугаар зүйл мөн Улсын Их Хурлын 23 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хэсэгт Төмөр замын газар байна гэж тус тус хуульчилсан.

Гэвч Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлахдаа батлахдаа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газрыг орхигдуулсан. ОХУ, БНХАУ болон төмөр замын чиглэлээр идэвхтэй харилцдаг бусад улс орнуудын төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг буюу Төмөр замын газартай байдаг.

Өнөөгийн байдлаар Монгол Улс хөрш орнуудтай ижил түвшний байгууллага байхгүйгээс тус үүргийг Улаанбаатар төмөр зам хувьцаат нийгэмлэг гүйцэтгэсээр ирлээ. Мөн сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд төмөр замын тээврийн салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд бий болж, хэрэглэгчийн тоо өссөн бөгөөд 2007 онд хууль батлагдаж байх үед суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч 1 байсан бол өдгөө суурь бүтэц эзэмшигч 4, тээвэрлэгч 4, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 253, дагнасан болон салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 250 орчим болж нэмэгдсэн бөгөөд төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ 14,8 сая тонн байсан бол 24 оны байдлаар 42,5 сая тонн болж 2,8 дахин нэмэгдсэн. Салбарт нийт 15 мянга орчим хүн 1115км замыг хариуцан ажиллаж байсан бол ойрын үед хэрэгжихээр шийдвэр гарсан төмөр замуудтай нийлээд сүлжээний нийт урт 4200км болж 3,7 дахин өссөн. Энэ хэрээр ажиллах хүчний тоо 50 мянга болж, 3,3 дахин нэмэгдэх тооцоолол гарч байна.

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдах Төмөр замын газар нь өсөн нэмэгдсээр байгаа тээврийн хэрэгцээг хангах, төмөр замын суурь бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгч хоорондын харилцааг зохицуулах, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, салбарын боловсон хүчнийг мэргэшүүлэх, төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчлэх, тээврийн сүлжээг өргөжүүлэх, төмөр замын чиглэлийн судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан, технологи, инновацыг нэвтрүүлэх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төмөр замын салбарт мөрдөх дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох, төмөр замын тээврийн үйлчилгээнд оролцогч олон өмчийн хэлбэрийн хуулийн этгээдийн зах зээлийн өрсөлдөөний тэгш байдлыг хангах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газрыг байгуулахдаа Зам, тээврийн сайдын 2025 оны төсөвт багтаан Галт тэрэгний хөдөлгөөний зохицуулалтын нэгдсэн төв төрийн үйлдвэрийн газрыг татан буулгаж, мөн Зам, тээврийн яамнаас агентлагийн чиг үүргийг хэрэгжүүлдэг тодорхой тооны орон тоог шилжүүлэх замаар улсын төсөвт аливаа нэгэн дарамт учруулахгүйгээр

байгуулахаар төлөвлөсөн болно. Иймд Зам, тээврийн тухай хуулийн 2025 оны 1 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Төслийн танилцуулга, төслийн үзэл баримтлалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого бичиг баримт батлагдсан 2010 онд. Тэгэхээр энэ батлагдсан бодлого бичиг баримтын дагуу бол яах вэ хойноос орж ирж байгаа Наушикар дамжиж орж ирж байгаа тэр төмөр замыг салаалгах юм уу, аль эсвэл хөндлөн гарсан тохиолдолд заавал өргөн төмөр замтай байна гэсэн ийм заалттай. Хэрвээ уул уурхайн боомтоос уул уурхайн ордоос хилийн боомт хүртэл зам тавих тохиолдолд ямар царигтай байх тухай асуудлыг Засгийн газар Их хурал руу оруулж ирж шийддэг ийм зүйл байгаа. Тэгэхээр ер нь нэг хэсэг царигийн асуудал нь маш их ярьдаг байсан. Энийг нэг өөрчлөх зайлшгүй шаардлага байгаа.

Өөрөөр хэлбэл уул уурхайн, жишээ нь Орос руу гарлаа гэхэд өргөн төмөр замаараа, Хятад руу гарлаа гэхэд нарийн царигаа төмөр замаараа тавьчих юм бол тэр бүтээгдэхүүн ямарваа нэгэн зардалгүйгээр, дээрээс нь хилийн нэвтрэлт болон бусад зүйл маш хурдтайгаар экспортоо нэмэгдүүлэх ийм боломж нь бий болно гэж би хараад байгаа юм л даа. Тийм учраас өнгөрсөн парламентад 2017 онд би нарийн, уул уурхайн ордоос хилийн боомт руу тухайн орны хилийн, тухайн орны царигаар тавих тухай тогтоолын төслийг өргөн барьсан. Гэвч өнгөрсөн парламент хэлэлцэлгүй байж байгаад сая шинэ Дэгийн тухай хуулиар надад буцаагдаж ирсэн байгаа. Тийм учраас энийг дахин өргөн барих талаар бас Засгийн газраас санал авч байгаа. Энэ дээр та ямар бодолтой байгаа вэ? Ямар, энэ ер нь цаашдаа бид энэ 2 оронтойгоо тухайн орныхоо бодлогыг хамтдаа өөрсдийнхөө гол зорилго дээр тийм ээ, хамтдаа байх талаар илүү нээлттэй байх юм уу даа гэж би хараад байгаа юм л даа. Тийм учраас энэ дээр Засгийн газар ямар байр суурьтай байх юм бэ? Цаашдаа яаж энэ экспортоо нэмэгдүүлэх энэ талаар яаж ажиллах юм бэ гэдэг дээр асуумаар байна.

Ж.Бат-Эрдэнэ: Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Ер нь өмнө нь энэ асуудал нэг биш удаа яригдаж байсан. Өмнөх парламентад Пүрэвдорж гишүүн энэ хуулийн төслийг өргөн барьж байсныг би сайн санаж байна. Бид 2 хөрштэй хиллэдэг. Нэг нь өргөн царигийн төмөр замыг эзэмшдэг, нөгөөдөх нь нарийн царигийн төмөр замыг эзэмшдэг ийм 2 хөрш байгаа. Тэгээд өөрийн чинь хэлж байгаагаар бид аль болохоор эдийн засгийн ач холбогдлоо бодсон ч гэсэн, мөн уул уурхайн бүтээгдэхүүнийг голдуу урагшаа БНХАУ руу экспортолдог учраас нарийн царигийн төмөр замыг Засгийн газрын гишүүний хувьд дэмжиж байгаа. Тэгээд энэ бол яагаад энийг дэмжиж байгаа юм гэхээр зэрэг нарийн цариг уул уурхайн бүтээгдэхүүнийг уул уурхайн олборлолт хийж байгаа уурхайгаасаа шууд ингээд экспортоор гарахад 1 дүгээрт дахин ачилт хийхгүй эдийн засгийн ач холбогдолтой.

2 дугаарт гуравдагч орон транзитаар дамжин өнгөрөхөд их ач холбогдолтой гэж үзэж байгаа учраас энэ хуулийн төсөл хэрвээ Улсын Их Хурлаар ороод батлагдвал Зам, тээврийн яам хэрэгжүүлээд явахад татгалзах зүйлгүй гэж үзэж байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн асуултаа асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ 23 онд хууль нь батлагдаад, шинэчилсэн найруулгаар тэгээд Улсын Их Хурлын тогтоол гараад, ингээд асуудал хариуцсан агентлагтай байна гээд хуульчилсан байхад 25 оны бүтцэд яахаараа ордоггүй юм, яахаараа орхигдуулдаг юм бэ? Тэгээд орхигдож байна гэдэг бол тухайн үед сайд нь яам нь юу хийж байсан юм бэ, яагаад энэ Засгийн газрын бүтцэд оруулах асуудал нь хаягдаад явж байхад бүхэл бүтэн асуудал хариуцсан яам нь орхигдчихсон байна гээд өнөөдөр нөхөж оруулж ирж байгаа юм Энэний учир шалтгаан нь юунд байна вэ?

Тэгээд танилцуулга дээр энэ агентлагийн хийх чиг үүрэг нь 10 орчим чиг үүргүүд байна. Тэгээд ингээд харахаар үнэхээр л зайлшгүй байх ёстой л юм шиг харагдаж байх юм. Тэгээд энэ чиг үүргүүдийг өнөөдөр хэн гүйцэтгэж байгаа юм, ямар субъект хариуцаж байгаа юм бэ? Энэ чиг үүргүүд үйл ажиллагаа явагдаж байна уу, явагдахгүй байгаа юм уу? Агентлаг нь байхгүй болохоор хийж хэрэгжүүлж чадахгүй байна гэх гэж байна уу? Энэ дээр нэг хариулт тайлбар өгөөч.

Төсөв санхүүгийн асуудал ямар хэмжээний төсөвтэй байх юм энэ агентлаг, ямар бүтэц орон тоотой байх юм, хэчнээн хүнтэй байх юм, одоо яамнаасаа зохицуулаад явчих юм уу, шинээр шинэ орон тоонуудыг бий болгох юм уу? Тэгээд энэ чинь улсын төсөв батлагдчихсан шүү дээ. Тэгээд энэ агентлагийн төсвийг яах юм бэ? Сайд багцаасаа зохицуулалт хийж явах гэж байгаа юм уу? Бүхэл бүтэн агентлаг гэдэг чинь дор хаяж 30, 40 хүнтэй байж л таарна. Энэ хүмүүсийн орон тоо, цалин мөнгөний асуудлыг яах гэж байгаа юм бэ? Төсөв батлагдсаны дараа 10 хоноогүй байж байхад шинэ төсөв хэрэгжээд, төсвийн жил эхлээд явж байхад агентлагийн асуудлыг ярьж орж ирж байна гэдэг чинь ер нь ямар асуудал юм бэ? Энэ болгон дээр тайлбар өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Тэгээд таны асууж байгаатай би санал нэг байна. Ер нь анх Засгийн газарт энэ бүтцийг хуулийн дагуу энэ зам, тээврийн газар агентлаг байна гэдэг бүтцийг оруулж ирсэн боловч харамсалтай нь манай ЗГХЭГ дээр энэ технологийн алдаа гаргаад, тэгээд үлдсэн гэдэг ийм тайлбар өгдөг юм. Тэрнээс биш энэ бол ямар нэгэн яамны зүгээс ийм агентлагаа байгуулна гэдгээ оруулж ирсэн 1 дүгээрт. Тэгээд дараа нь ингэж Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвч шинэчлэн батлахад ингэж нэмж оруулж ирж байгаа, хаягдчихсаныг нэмж оруулж ирж байгаа орхигдчихсоныг 1 дүгээрт тэр.

2 дугаарт бүтцийн хувьд 36-аас 38 хүний орон тоотой ийм агентлаг байгаа. Өнөөдөр Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв дээр 23-аас 24 хүн ажилладаг. Энэ Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв дээр суурилагдаж байгуулагдаж байгаа агентлаг. Дээрээс нь Зам, тээврийн яам дээрээс энэ төмөр замыг хариуцсан 13 ажилтан тийшээ шилжээд, үндсэндээ 36-аас 37 хүний орон

тоотой ийм агентлаг байх юм. Энэ юуны хувьд санхүү энэ агентлагийг цаашдаа авч явах энэ юу нь бол ингээд Зам, тээврийн сайдын энэ багцад угаасаа тавигдчихсан ийм байгаа учраас дахиж Төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, ямар нэгэн төсөвт дарамт ирэх тийм асуудал гарахгүй гэдгийг энэ ташрамд хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Ямар байсан агентлаг байгуулах асуудал орж ирлээ. Ер нь бид хуульдаа агентлагтай байна гээд заачихсан байгаа. Одоогийн ажиллаж байгаа Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах төв тийм ээ, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах төвийн үйл ажиллагааг үндсэнд нь агентлаг болгоод энийг цаашаа авч явах гэж байгаа шүү дээ. Тийм болохоор энд байгаа санхүүгийн болон ... юмнууд чинь шууд шилжээд явчихна тийм үү. Төсөв нь шууд шилжээд орчихно. Ер нь бид урьд өмнө Улаанбаатар төмөр зам гээд ганцхан төмөр замтай байсан төмөр зам компанитай байсан суурь бүтцээ ч эзэмшдэг, тээвэрлэгчээ ч хийдэг байсан. Одоо бол суурь, бүтэц тээвэрлэгч 2 маань салчихсан.

Дээрээс нь хувь болон төрийн өмчит ийм компаниуд нэлээн олон гарч байсан шүү дээ 4, 4 байгаа байх тийм үү. Суурь эзэмшигч нь 4 байна, нөгөөдөх нь тээвэрлэгч 4 байгаа байх. Тэгэхээр эд нарын хоорондын харилцааг зохицуулах ийм зайлшгүй шаардлага байгаад байгаад байгаа. Тэгэхээр энд агентлаг бол агентлагийн хэмжээнд ажиллах, тодорхой хэмжээнд хууль дүрэм мөрдүүлэх ийм зайлшгүй шаардлага байгаа шүү. Тийм болохоор энэ сая Сандаг-Очир гишүүний хэлдэг үнэн шүү дээ. Ер нь Засгийн газар оруулж ирээд батлаад явах ёстой байсан ингээд хойшлуулчихаад, ингээд төсөв батлагдсаны дараа нэг иймэрхүү зүйл хийгээд явж байх шиг байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Сайнзориг, Зулпхар, Бямбацогт гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Төмөр замын агентлаг байгуулах асуудал зарчмын хувьд дэмжиж байна. Хууль гарсан, хэрэгжүүлээд явах нь зөв байх. Тэгэхдээ аль болохоор цаашдаа төр дээр шаардлагатай, шаардлагагүй бүтцүүд аль болохоор нэмэхгүй байх зарчим ер нь бариасай гэж бодож байгаа. Энийгээ хэлье. Энэ агентлагийн хувьд эдийн засгийн тулгуур болсон тээвэр логистикийн төвийн түрүүн Бат-Эрдэнэ дарга хэлж байна. Хэд хэдэн хувийн хэвшил ч гараад ирлээ. Эдгээрийн үйл ажиллагааг хувьд зохицуулах учраас энэ бол улс орны эдийн засагт томоохон чухал үүрэгтэй ийм ач холбогдолтой агентлаг байна гэдэг зарчмаар нь дэмжиж байгаа гэдэг зүйлийг хэлмээр байна.

Би зүгээр хэлэх гэж байгаа үг дээрээ Дэлгэрсайхан сайдад энэ төмөр замын Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого гээд нэг ийм улс орны эдийн засгийг чөдөрлөсөн нэг ийм бодлого байна. Зарим зүйлүүд нь зөв байгаа юм, хэрэгжээд явж байна. Зарим зүйлүүд нь огтоосоо болдоггүй. Тэгээд сүүлдээ энэ төмөр замын баримтлах бодлого дээр нь хүртэл Цэц хүртэл орж ирж Цэцэд хамаагүй асуудлаар Цэцийн шийдвэр гаргаж энэ бүх нөхцөл байдлуудыг улам даамжруулж байгаа юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсын эдийн засгийг одоо яг бүрэн зогсоочоод байгаа нь саад болж, боломжийг алдагдуулсан 12 жилээс гадна энэ төмөр замыг ашиглалтад орох хүртэл энэ хугацаанууд чинь үргэлжлээд сунаад явж байгаа байхгүй юу. Ийм зүйлүүд байх юм.

Тэгээд төрөөс Монгол Улсын хөгжлийн бодлогыг төлөвлөдөг хуультай болсон. Энэ дээр урт хугацааны бодлого нэгтэй байна, дунд хугацааны бодлого нь 10 жил байна, тэгээд богино хугацааны бодлогууд байгаа. Гэтэл энэ төмөр замаа

Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого нь 2010 онд батлагдсан, хэрэгжээд нэг дүгнэлт өгөх хугацаа нь бүүр 20 онд болчихоод байгаа байхгүй юу. Одоогийн мөрдөж байгаа хуулиар. Тэгэхээр энэ Ганцмод-Гашуунсухайт ч гэдэг юм уу энэ хил холболтын асуудлууд нь нэгэнт шийдэгдээд явах магадлалтай энэ төмөр замын холболтын цэгүүдээсээ гадна бусад юунуудаа нэг тодорхой болгомоор байна. Энэ хувийн уурхай руугаа төмөр зам татдаг асуудлыг хүртэл ийм бодлого шингээгээд оруулчихсан зарим улс төрчид нь явж байгаа шүү дээ.

Тэгээд өнөөдөр Монгол Улсын төмөр замаар ОХУ-ын бараа, бүтээгдэхүүн хөнгөлөлттэй үнээр гараад явж байхад бид энэ асуудлаа ерөөсөө ашиглаж чадахгүй. Бид хойгуур яваад Владивостокоор бусад гуравдагч орон руу гарна гээд ийм үлгэрийн юм яриад явж байдаг. Хятад улстай тэр транзит буюу манай тодорхой экспортолж байгаа бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээтэй дүйцэхүйц 1/3 хэмжээтэй дүйцэхүйц бараа, бүтээгдэхүүн хөнгөлөлттэй үнээр Хятадын газар нутгаар тээвэрлэх асуудлыг бид ярих ёстой. Энийгээ ингээд явах. Тэгэхээр энэ Төрөөс баримтлах бодлогыг нь нэг эргэж хараад, сайжруулахыг нь сайжруулаад энэ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулах, эргээд энэ Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуультай нийцүүлэх ажлыг нэг ойрын хугацаанд хийгээч.

Тэгээд энэ зүйлүүдийг хийхгүй бол дахиад л энэ эрх ашгууд яг цаашдаа бас ойлгомжгүй явна. Тэгэхээр энэ Ганцмод-Гашуунсухайт, цааш цаашдын холбогдох 2, 3 төмөр замын холболтын цэгүүдтэйгээ уялдуулаад, ер нь урт хугацаандаа Монгол Улсын төмөр замын бодлогыг дахиад яг энэ 126 парламентын гишүүн байгаа дээр цэгцэлж, урт хугацааны бодлоготойгоо нийцүүлж энэ эдийн засгийн төлөвлөлтийн хувьд ер нь хаачих гэж байгаа гэдгээ зөв гаргамаар байна. Энэ тэгээд төмөр замыг энэ зарим баруун бүсийн аймгуудаар гаргах асуудлууд энэ хэр явах юм бэ? Яриад л яваад байдаг ерөөсөө нэг ийм буруу зөрүү мэдээлэл өгөөд ерөөсөө бас л ингээд нэг тийм ойлгомжгүй нөхцөл байдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр миний хэлэх гэж байгаа санаа бол энэ Төмөр замын агентлаг гэхээсээ илүүтэйгээр энэ агентлаг байгуулагдаж байгаа бол энэ бодлогыг нэг эргэж харж дүгнэлт өгөөч. Тэгээд энэ дээр улс төржилт гэдэг юм уу, энэ хувийн эрх ашгуудыг хэт шингээсэн зүйлүүдийг цэгцлэхийг нь цэгцлээд, нийтлэг эрх ашгуудыг эдийн засгийн энэ тулгуур салбар болох тээвэр логистикийн төвүүдээ цэгцтэйнхэн шиг нийтлэг.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Энэ Их Хурлын тогтоолын төслийг зарчмын хувьд бүрэн дэмжиж байна. Энэ асуудал бид төсөв хэлэлцэх үеэр тодорхой саналууд гарсан шүү дээ. Бид яах вэ гарсан хэлбэр нь яах вэ жоохон асуудалтай байсан байж болох юм. Ер нь тухайн үед гарч байсан санал бол бид зорилгодоо нийцсэн бүтэцтэй байх юм уу, үгүй юу гэдэг шийдвэр аль хэзээний гарчихсан байсан. Хууль нь батлагдчихсан, дагалдах Их Хурлын тогтоол гарчихсан байсан. Энийг л бид хангуулъя гэдэг зүйл ярьж байсан. Сая яах вэ Хэрэг эрхлэх газар дээр техникийн алдаа гарсан юм шиг байна. Тэр гарсан байж болно. Гэхдээ энийг засаад явах нь бидний асуудал. Тухайн үед ч гэсэн ярьж байсан. Тэртээ тэргүй энд ажиллах төрийн албан хаагчид нь 2 үндсэн субъектээс өөрөө бүрэлдэх юм. Холбогдох төсөв нь ч гэсэн байгаа гэдэг ийм л хариулт өгч байсан. Тэгэхээр энийг бид дэмжих ёстой байх гэж бодож байна.

Та бүхэн харж байгаа байх. Бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг жишээ нь баталчихсан. Манай Алсын хараа 20 50 баримт бичиг дээр ч гэсэн бид төмөр замыг манай улсын эдийн засгийн түүн дотроо тээвэр логистикийн гол тулгуур гээд жишээ нь тодорхойлж өгсөн байгаа юм. Тэгээд энэтэй уялдсан энэ харилцааг бодлогыг хэрэгжүүлдэг төрийн захиргааны байгууллага нь байгаагүй учраас энийг байгуулъя гэдэг ийм л Их Хурлын шийдвэр урьд нь гарчихсан байсан. Тэрийг бид гаргаж байгаа ийм хэлбэр учраас бид энийг тал талаасаа дэмжиж шийдвэрийг нь гарах ёстой гэж бодож байна.

Нэг жоохон зохион байгуулалтын шинжтэй юмнууд гарах байх. Гэхдээ хүнд юм болохгүй байх. Яаманд байгаа албан хаагчид бол төрийн захиргааны албан хаагчид. Төв дээр байгаа албан хаагчид бол төрийн үйлчилгээний албан хаагчид. Тэгэхээр агентлаг бол өөрөө жишээ нь Агентлагийн хуулиар ч гэсэн, Төрийн албаны хуулиар ч гэсэн төрийн захиргааны албан хаагч нар байгаа юм. Тэгэхээр энэ дээр та бүхэн дүйцүүлэх энэ хэлбэрийг, энэ зохион байгуулалтыг шуурхай хийх хэрэгтэй байх гэж бодож байна. Үйлчилгээний албан хаагчид төрийн захиргааны албан хаагч болж ажиллахад нэлээн амаргүй ийм сорилтууд гардаг шүү. Энийг шуурхай давах ёстой. Бид энэ шийдвэрийг гаргаж байгаагаараа маш чухал шийдвэр гаргаж байна. Энийг тал талаас нь гаргаж, шийдвэр гаргаж дэмжих ёстой гэж ойлгож байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Бямбацогт сайд үг хэлнэ.

С.Бямбацогт: Би бас дэмжиж байгаа юм. Тэгээд яах вэ өнгөрсөн жил нөгөө сонгууль болоод засаг солигдоод тодорхой наана, цаана гэж байгаад энэ агентлаг хуулийн дагуу байгуулагдах ёстой агентлаг маань ингээд хоцорчихсон. Тэгээд одоо нөхөж ингэж байгуулах ёстой болсон. Агентлаг байгуулахтай холбоотойгоор улсын төсөвт ямар нэгэн тодотгол хийх нэмэлт дарамт учрахгүй. Одоо байж байгаа Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, мөн Зам, тээврийн хөгжлийн яаманд ажиллаж байгаа Төмөр замын бодлого, зохицуулалтын газрын орон тоонуудыг нийлүүлээд ингээд дарамтгүйгээр агентлаг байгуулаад явчихъя гэж байгаа юм. Энийг гишүүд зөв ойлгох байх гэж бодож байна.

Тэгээд энэ дээр 2010 онд Төмөр замын талаар төрөөс баримтлах бодлого батлагдаж байх үед Төмөр замын тухай хууль энэ нэмэлт, өөрчлөлт хийгдэж байх үед Монгол Улс ганцхан төмөр замтай байсан 1100км урттай, Орос Хятадыг холбосон. Энэ төмөр зам 70-аад жил 49 онд Оростой, 56 онд Хятадтай холбогдсон. Тэр үеийн нөхцөл байдал өнөөдрийн нөхцөл байдал 2 өөр болчихоод байгаа юм л даа. Тэр үед Улаанбаатар төмөр зам гэж ганцхан компани энэ 1100км төмөр зам дээр суурь бүтцийг нь эзэмшээд, тээвэрлэлтээ хийгээд, салаа салбар замуудаа хариуцаад ажилладаг байсан. Өнөөдөр үндсэндээ 4 төмөр замтай болсон. Гаднын хөрөнгө оруулалттай, хувийн хөрөнгө оруулалттай, төрийн өмчийн Орос, Монголын хамтарсан гээд олон янзын. Энэ төмөр замуудын бодлого, үйл ажиллагааг хооронд нь зохицуулах, нэг суурь бүтэц эзэмшигч буюу төмөр зам эзэмшиж байгаа компани 4 болсон, тээвэрлэгч нь 4, 5 болчихсон. Мөн төмөр зам барих тусгай зөвшөөрөлтэй компаниуд нь 250, төмөр замын салаа салбар зам эзэмшиж байгаа компаниуд нь 3, 400 болчихсон. Өнөөдөр ийм болчихсон.

Тэгэхээр энийг нэгдсэн тийм төрийн захиргааны байгууллага бодлого, зохицуулалтыг нь хийж албажуулж явахгүй бол нэг төсөвт үйлдвэрийн газраар

явахад төвөгтэй болчихоод байгаа юм. Цаашдаа бид ганцхан төмөр замтай биш Орос, Хятадыг холбосон 3 төмөр замтай болох гэж байгаа. Баруун босоо төмөр, зам зүүн босоо төмөр зам. Энэ Орос, Хятадыг холбосон томоохон төмөр замууд баригдана. Энэний зохицуулалт энд гадна, дотнын хөрөнгө оруулалт олон асуудал яригдана. Дахиад л нөгөө нэг Гашуунсухайт-Ганцмодны төмөр замтай адилхан танк орж ирнэ гээд л хэдэн жил 10 хэдэн жил, 20-иод жил ингээд маргаад нарийн байх ёстой, өргөн байх ёстой гээд ингээд суухгүйн тулд энэ бас агентлаг байх хэрэгтэй болж байгаа юм.

Ачаа тээвэрлэлтийн хувьд ч гэсэн 10 жилийн өмнө 10 хэд 12, 13 сая тонн ачаа тээвэрлэдэг байсан бол одоо 36 сая тонн ачаа тээвэрлэдэг болчихсон. Цаашдаа энэ төмөр замууд баригдаад явагдахаар дахиад 40, 50 сая болно. Урагшаа ганцхан Замын-Үүд Эрээний боомтоор төмөр замаар холбогдсон бол бид Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч, Хангимандал гээд 5 төмөр замаар холбогдоно. Энийг дагаад ачааны экспортын хэмжээ 50, 60 сая, 100 сая тонн болоод явна. Тийм болохоор Монгол Улсын эдийн засагт валютын нөөцийг нэмэгдүүлэхэд, ажлын байрыг бий болгоход, ажиллаж байгаа ажилтан албан хаагчийн тухай ч ялгаагүй 10 гаруй мянган хүн ажилладаг байсан бол өнөөдөр 40 гаруй мянган хүн ажиллаж байна. Цаашдаа маш олон мянган 100 мянга хүртлээ ажлын байр нэмэгдэх ийм боломжтой юм. Тийм болохоор энэ том өнөөдрийн байж байгаа нөхцөл байдал маань өсөн нэмэгдэж байна. Цаашдаа улам өсөн нэмэгдэх Монгол Улсын эдийн засагт маш чухал стратегийн ач холбогдол бүхий салбар болж байгаа. Энэ бүгдийг л харгалзаад энэ агентлаг байгуулах асуудлыг Засгийн газраас оруулж ирж байгаа.

Тэгээд энийг бүгдээрээ нэг ойлгоод, дэмжээд явчихъя. Ер нь төрийн данхар бүтцийг цөөлөх, тодорхой үр ашиггүй, шаардлагагүй төрийн албан хаагч, орон тоог цомхотгох барих асуудал байж болно. Төмөр замын агентлагийн тухайд зайлшгүй нэн шаардлагатай, эдийн засагт ач холбогдолтой, ард иргэдийн амьдралд нэн чухал учраас зайлшгүй ийм төрийн захиргааны байгууллага байгуулж, зохицуулалт хийх шаардлагатай байгаа юм. Энийг манай гишүүд ойлгоно байх гэдэгт итгэж байна. Тэгээд дэмжиж өгөхийг хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж дууслаа. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 68,8 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, хэлэлцэх эсэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт танилцуулна.

14.57 цаг

Гурав. “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүнээс 2024.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн заалттай холбогдуулан асуулт асуух саналтай гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Алга байна. Эхний хэлэлцэх эсэх, тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. 4 саналаа нэг дор явчих уу. Нэг нэгээр нь, энэ дотор байхгүй байна уу. 4 санал байгаа юм байна шүү гишүүдээ.

1.Төслийн гарчгийн “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” гэснийг “Засгийн газарт чиглэл өгөх тухай” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд. Санал хураалт. 16 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 62,5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн тэмдэглэх хэсгийн “БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, бүрэн эрхт элчин сайд, ХХ зууны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор” гэснийг хасах. Санал хураалт. Санал гаргасан С.Эрдэнэболд. 16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56,3 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1.БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, хөдөлмөрийн баатар, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заасны дагуу Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэх өдрийн товыг тогтоож, ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

2/Жамсрангийн Самбуугийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, төрийн албыг төлөвшүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;

3/ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дээр нь явсан, 16 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 50 хувиар санал дэмжигдсэнгүй шүү дээ. Сандаг-Очир гишүүн горимын санал гаргая. Сандаг-Очир гишүүний микрофон.

Ц.Сандаг-Очир: Сая санал хураалтад оролцож амжсангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгоод, дахин санал хураалгаж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 56,3 хувиар санал дэмжигдлээ. Горимын санал хүчингүй болсон тул санал хураалт явуулъя. Санал хураалт. 16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56,3 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар заалтын “үүрэг болгосугай” гэснийг “даалгасугай” гэж өөрчлөх. Саналын томъёоллыг дэмжье гэснээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 16 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 62,5 хувиар санал дэмжигдлээ. Ингээд “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндчилсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд танилцуулах уу? Хэн? Баярбаатар гишүүн танилцуулна.

15.04 цаг

ТББХ-ны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

